

# ММСГН-ийн 2018 оны ажлын товч тайлан

2019 оны 1-р сарын 21.

Нэг. Монголын Материал Судлал Гагнуурын Нийгэмлэгээс тайлангийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаар.

1. ММСГН-ээс 2018 онд хийгдэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.

2. Нийгэмлэгийн үндсэн зорилго, үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүст сурталчлах, танилцуулах ажлыг явуулж ирэв.

3. ММСГН-ийн [www.mmsws.mn](http://www.mmsws.mn) веб сайтыг байнга ажиллуулж, мэдээллүүдийг шинэчилж ажиллаа.

4. Нийгэмлэгт гагнуурын ажил төрлөөр хандаж туслалцаа хүссэн, зөвлөгөө авах, гагнуурын ажлын чанар шалгуулах, холбоо тогтоох, гагнуурчин бэлдэх, шалгуулах зэрэг хүсэлтүүдийг хүлээн авч туслалцаа дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллан тухай бүр нь шийдвэрлэж ирэв.

5. Эрдэс Баялаг Эрчим Хүчний Сайдын 2010 оны 01-р сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан „Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох дүрэм”-ийн дагуу Даян ХХК, Оюутолгой ХХК, Хасумегаватт ХХК, MCS LLC, REDPATH LLC зэрэг 20 компани 217 гагнуурчид болон ГММСҮТ ийн сургалтад хамрагдсан 134 төгсөгч, нийт 351 хүнээс мэргэжлийн шалгалт авч гэрчилгээ олгосон.

6. Гагнуурын мэргэжлээр суралцагсдын дунд явуулдаг „Монгол үр чадвар- 2018” гагнуурын 1-р шатны тэмцээнийг ХНХЯам, Хасу- Мегаватт ХХК-тай хамтран ГММСҮТөв дээр 2018 оны 1-р сарын 25- 27-ний өдрүүдэд зохион байгуулав. Тэмцээн олон улсын стандартын дагуу дэлхийн үр чадварын тэмцээний дагуух сорьц ашиглан цахилгаан гар нуман гагнуур, хагас автомат, аргон гагнуур гэсэн 3 төрлөөр явагдсан. Тэмцээнд хот хөдөөгийн 27 сургуулийн 32 оролцогч үр чадвараа сорьж хөндлөнгийн шүүгчдийн гадна үзлэг, эвдэх болон үл эвдэх аргаар хийсэн үнэлгээгээр Т.ОюунЭрдэнэ /ГММСҮТ/ 7.94, Э.Уужимсэтгэлт /Мо-Со ПК/ 7.88, Б.Баттогтох /ТТДС/ 6.90, Э.Бөхболд /ТТДС/ 5.14, Д.Нямрагчаа /ГММСҮТ/ 5.04, О.Төгсөө /Дорнот МСҮТ/ 4.74 оноогоор тус тус байр эзэллээ.

7. Нийгэмлэгийн гишүүд Л.Энхбаяр, О.Мөнхзул, Н.Мягмарсүрэн нар „ Эрчим хүчний салбар дахь материал судлал, гагнуурын техникийн шаардлага, стандартын зохицуулалт” сэдвийн дор гагнуурын стандарт, зохицуулалтын асуудал үлс орны хэмжээнд тулгамдсан асуудал

болж буй болон хэрхэн шийдэх талаар хөндсөн нийтлэл бичин Монголын Инженерүүдийн холбооны шилдэг өгүүллийн уралдаанд оролцож 4-р байр эзэлсэн.

8. Монголын мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд гагнуурын мэргэжлээр суралцагсдын дунд зохион байгуулдаг „Монгол үр чадвар-2018” тэмцээний сүүлийн шатны шалгаруулалтын тэмцээнийг Эрчим хүчний хөгжлийн төвийн харьяа Сургалт үйлдвэрлэлийн төв дээр ХНХЯамтай хамтран 12-р сарын 3-7 өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Тэмцээнд ГММСҮТ-ийн Оюун-Эрдэнэ 50.6 оноогоор түрүүлж Монгол Солонгосын Полтехник коллежийн суралцагч Э.Уужимсэтгэлт 20.1 оноогоор удаалав. Оюун-Эрдэнэд ирэх жил ОХУ-д болох „WORLD SKILSS KAZAN” дэлхийн үр чадварын 45 дах удаагийн тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцох эрхийн бичгийг ХНХЯ-аас гардуулав.

Бүх сорьц, материал болон шүүгчдийг Нийгэмлэгээс зохион байгуулав. Анх удаа БНСУ -ын гагнуурын мэргэжлийн хүн хөндлөнгийн экспертээр тэмцээнд оролцов.

9. China international welding competition-2018 тэмцээн 2018 оны 7-р сарын 25-30 өдрүүдэд БНХАУ-ын Хунан мужийн Жожоу хотод болсон. Энэ тэмцээнд ГММСҮТ-ийн Т.Оюун-Эрдэнэ, эксперт С.Батсайхан нарыг нийгэмлэгийн гишүүн Хасу-Мегаватт ХХК ивээн тэтгэж оролцуулав. Тэмцээнд нийт 6 орон оролцож Т.Оюун-Эрдэнэ 5-р байр эзлэв.

Гагнуурын 4 төрлөөр ДУЧ-ын тэмцээний даалгавраар хийсэн тэмцээнд манай оролцогч хүрэл медаль хүртсэн.

10. ММСГНийгэмлэг ХНХЯамтай хамтран 2018 оны 9-10-р сард БНСУ-д эксперт С.Батсайхан Мон-Со ПК Э.Уужимсэтгэлт нарыг гагнуурын дадлага хийлгэлээ.

10-р сарын 5-10-нд болсон БНСУ-ын үндэсний тэмцээнд Э.Уужимсэтгэлт оролцож 5 модуль гагнан, авбал зохих 100 онооноос 40.04 оноо авсан.

Энэ арга хэмжээ нь манай гагнуурын мэргэжилтэн, гагнуурчин нар ихийг сурч мэдсэн маш үр дүнтэй ажил боллоо.

11. Мэргэжлийн гагнуурчдын 2017 оны улсын аваргын болон Монгол үр чадвар тэмцээнүүдээс шалгарч БНХАУ-ын Хунан мужийн Жожоу хотод болох олон улсын гагнуурчдын „ARC CUP- Internatinal Welding competetion-2018” тэмцээнд оролцох болсон төрийн болон хувийн хэвшлийн 15 гагнуурчдыг ГММСҮТөв дээр ажлын 7 өдөр үндсэн ажлаас нь чөлөөлөн бэлтгэл хийлгэх ажлыг нийгэмлэг зохион байгуулав. Бэлтгэл ажилд шаардлагатай сорьц, бэлдэц, материал зэргийг нийгэмлэг гаргаж бэлтгэлийн үйл ажиллагаа бүхэлд нь хянаж зааварлаж ажиллаа.

12. БНХАУ-ын Хунан мужийн Жожоу хотод 2018 оны 6-р сарын 4-11-ний өдрүүдэд болсон мэргэжлийн гагнуурчдын олон улсын „ARC CUP -2018” тэмцээнд монголын гагнуурчдыг оролцуулах ажлыг нийгэмлэг зохион байгууллаа

Тэмцээнд нийт 21 орны 380 гагнуурчин оролцсон

Манай улсын төрийн болон хувийн хэвшлийн 15 гагнуурчин оролцов. Насанд хүрэгчдийн ангилалд MCS Х.Бямбажав цахилгаан гагнуураар алтан медаль, оюутны ангилалд ГММСҮТөвийн сурагч Д.Нямрагчаа хагас автомат төрлөөр алтан медаль, Мөнх Чандмань ХХК гагнуурчин Н.Энхбат аргон гагнуураар мөнгөн медаль, оюутны ангиллын төрөлд Мон-Со ПК сурагч Э.Уужимсэтгэлт цахилгаан гагнуураар мөнгөн медаль, насанд хүрэгчдийн ангилалд ДЦС- 4 ТӨХК гагнуурчин Э.Батсүх хийн гагнуурын төрөлд хүрэл медаль тус тус хүртсэн.

Мөн ДЦС-3 ТӨХК Б.Эрдэнэбаяр алт, Ж.Мягмарсүрэн мөнгө, М.Ганхуяг хүрэл, ДЦС-4 ТӨХК Ч.Агваандэмбэрэл мөнгө, Н.Ганцоож хүрэл, Хасумегаватт ХХК Б.Түвшинжаргал алт, Б.Өлзийбуян мөнгө, Эрчим хүчний хөгжлийн төв Ц.Хашмөрөн мөнгө авч ДДЦС ТӨХК Д.Хүрэлбаатар, ГММСҮТ Т.Оюун-Эрдэнэ нар шагналт байр тус тус эзлэв.

Монголын баг 4 алт, 6 мөнгө, 4 хүрэл нийт 14 медаль, 2 шагналт байр хүртэн багаараа анх удаа 1 р байрт орон цом гардан авч сайхан амжилт үзүүлээ.

С.Батсайхан зохион байгуулах хорооны шийдвэрээр эксперт шүүгчийн батламж гардан авсан.

13. 2018 оны 10-р сарын 24-27-өдрүүдэд ОХУ-ын Екатеринбург хотод WORLD SKILSS Hi-Tech-2018 тэмцээнд ГММСҮТ Т.ОюунЭрдэнэ, Мон-Со ПК Э.Уужимсэтгэлт нар эксперт С.Батсайханы хамт оролцлоо. Оюутолгой ХХК ивээн тэтгэсэн.

Гагнуурын төрөлд гадаадаас Монгол, Энэтхэг, Казахстан зэрэг орнууд оролцож 4 үндсэн модультай техникийн даалгаврыг 4 өдөр нийт 18 цаг гүйцэтгэлээ.

Евроазийн шилдгүүд шалгаруулах номинацид хувийн амжилт нийт оноогоороо Монгол 2-р байранд шалгарсан.

14. ММСГНийгэмлэг АНУ-ын Атланта хотод 2018 оны 11-р сарын 8-10 өдрүүдэд зохион байгуулагдсан гагнуур, металл огтлогооны олон улсын „ FABTECH-2018” үзэсгэлэн яармагт Монголын аж ахуйн нэгж, компаны төлөөллүүдийг оролцуулах ажлыг амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэн яармаг болох гэж буй талаар зар мэдээллийг 2018 оны 6-р сарын 13-нд нийгэмлэгийн веб сайтад байршуулснаас гадна гол ААН- үүдэд албан тоотоор мэдэгдсэн.

Үүний үр дүнд 10 гаруй байгууллагын 25 хүн оролцох саналаа албан ёсоор ирүүлсэн.

Нийгэмлэгийн зүгээс тэднийг бүртгэх; Элчин яаманд албан тоот өгөх, урилга авах, тараах, зөвлөгөө өгөх, визанд цаг авч оруулах, даатгалд хамруулах, нислэгийн болон зочид буудлын захиалга өгөх, төлбөр тооцоо хийх, группийг ахалж авч явах, хүндрэлтэй асуудлыг шийдэх зэргээр ажиллаа.

Оролцохыг хүсэгчид олон байсан хэдий ч АНУ ын виза тал хувьд нь гараагүй

Үзэсгэлэн яармагт Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр ,ДЦС- 2 ТӨХК, ДЦС- 4 ТӨХК, Хасу Мегаватт ХХК, ZMEngineering ХХК, ММСГН- ийн төлөөлөл нийт 13 хүн оролцлоо.

Үзэсгэлэн яармагийг Desktop Metal, Mitsubishi Laser, Nissan Commercial Vehicles, Microsoft, UPG, Robovent, Mazak, MESSER зэрэг гагнуур огтлогооны тэргүүлэх зэргийн томоохон компаниуд ивээн тэтгэсэн, өндөр хөгжилтэй орнуудын сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийн өнөөдөр бодит амьдралд хэрхэн ашиглагдаж буйг үзүүлсэн. Манай оролцогчид эдгээртэй танилцаж, нүдээрээ харан, шууд холбоо харилцаа тогтоох боломжтой байснаараа үр дүнтэй арга хэмжээ болсон.

15.Гагнуурын мэргэжлээр суралцагсдын дунд үр чадварын тэмцээн явуулах TV шоу нэвтрүүлгийг 12- р сард Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/GIZ/-ийн ивээн тэтгэлгээр хийгдсэн. Энэ ажил ГММСҮТөвийг түшиглэн 4 сургуулийн 5 оролцогчтой явагдсан. Нийгэмлэгийн гишүүн Ч.Анхаа, С.Батсайхан, Н.Ганхуяг, О.Мөнхтөгс, Галхүү нарын идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан энэ шоу нэвтрүүлэг гагнуурын мэргэжлийг залуучуудад сурталчлахад үнэтэй хувь нэмэр оруулсан гэж дүгнэж байна.

16.Монгол үр чадвар тэмцээнээс шалгарсан 2 оролцогчийг Оюутолгой ХХК дээр болон ТЭЦ- 4 дээр бэлтгэл хийлгэх график ,төлөвлөгөө гаргах хяналт тавих ажлуудыг нийгэмлэгийн гишүүн С.Батсайхан идэвхтэй зохион байгуулж хийж ирлээ.

ХНХЯамны Казанийн дэлхийн үр чадварын тэмцээний бэлтгэл хангах ажлын хэсгийн гишүүний хувьд гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн хуралд нь оролцон санал дүгнэлтээ танилцуулж ажиллав.

17.ММСГН нь байгуулагдсанаасаа хойш мэргэжлийн гагнуурчдын болон мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд суралцагсдын хооронд гагнуурын үр чадварын тэмцээнүүдийг нийтдээ 8 удаа зохион байгуулж, олон улсын тэмцээнд 9 удаа оролцуулсан байна. Энэ нь гагнуурын мэргэжлийг сурталчлах, түршлага солилцох, шинэ техник технологитой танилцах, байгууллага, сургууль, гагнуурчдын дунд

өрсөлдөөнийг бий болгож улмаар тэдний үр чадварыг дээшлүүлэхэд томоохон түлхэц болж байна.

18. ММСГН-ийн 2017 оны үйл ажиллагааны дүнгээ Монгол улсын Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу Улсын бүртгэлийн газарт хугацаанд нь тайлагнасан. Мөн нийгэмлэгийн санхүүгийн тайлан татварын тайлан нийгмийн даатгалын тайланг улирал сар бүрээр хуулийн дагуу гаргаж тооцоогоо хийж ирсэн

19. Азийн Гагнуурын Холбооноос нэхэмжлэх ирээгүй тул татвар төлөөгүй. Энэ талаар 2 удаа mail явуулсан боловч хариу ирээгүй байна.

Хоёр. Нийгэмлэгийн ажилд оршиж буй алдаа дутагдал

1. АГХ ы зүгээс хэрэгжүүлж буй гагнуурчдаас шалгалт авч мэргэшүүлэх тогтолцоог Монголд хэрэгжүүлэх тал дээр ямар ч ахиц гараагүй. Холбооны үйл ажиллагаанд хангалтгүй оролцлоо.

3. Ажлын төлөвлөгөөнд орсон хэдий ч гагнуурын сургалт зохион байгуулж чадаагүй энэ чиглэлийн ажил муу байсан.

3. Материал судлалын чиглэлээр ажил хийгдээгүй

4. Нийгэмлэгээ сурталчлах ажил сул байна.

Гурав. Нийгэмлэгийн зүгээс цаашид нэн түрүүн хэрэгжүүлэх ажлын талаар

1. Гагнуурын багш мэргэжилтнүүдэд сургалтууд зохион байгуулах

2. Шинээр хүн ажилд авч нийгэмлэгийн ажлыг тогтмолжуулах

3. Нийгэмлэгийн тэргүүлэгчдэд төлөвлөгөөт ажлыг хуваарилан хариуцуулж ажиллах

4. Нийгэмлэгийн танилцуулга хийх

5. Гишүүнчлэлийг өргөтгөх

6. Мэргэжлийн гагнуурчдын улсын аваргын тэмцээнийг сайн зохион байгуулах

7. Монгол үр чадварын тэмцээний ялагчийн бэлтгэлийг тусгай төлөвлөгөө гарган сайн хангуулах

8.Дэлхийн үр чадварын WORLD SKILLS KAZAN-2019 д амжилттай оролцох

Тайлан гаргасан ..... /Н.Мягмарсүрэн/  
2019.01.23